

12th July 2021

Quarterly Report (April to June 2021) to Bank of Mongolia by Independent Director
Niraj Vedwa

I, Niraj Vedwa, Independent Director on Board of Xacbank, wish to state that I have performed my Duties in accordance with the Banking Laws as Defined by Bank of Mongolia and the Board Charter of Xacbank.

I have been Member of Board Audit and Risk Management Committees and participated in all Monthly Update Calls as well as the Quarterly Board Meetings held on 29th and 30th June. I also participated in the EGM held on 22nd June where all the Shareholders and Directors were present. Due to Covid and travel restrictions, all Board meetings were held over Video Conference.

All the meetings were conducted smoothly and effectively and agenda items and reading materials were circulated prior to the meetings. All decisions were based on voting by members. I was in agreement on the consensus that was obtained by participation of all Board members in respective committees and did not have any difference of opinion. There was No Conflict of Interest transactions in the agenda.

Xacbank maintained strong Corporate Governance and maintained its reputation as one of the Best managed Banks in Mongolia. As Independent Director, I support the “Good Corporate Governance” throughout the quarter and year.. Through the various meetings, I was involved in Discussions, Review and Implementation of Bank Strategy / IT Strategy / Digital / Risk Management Policy / Audit Committee / Budgets / Business plans. Was also involved in review and setting up Internal Audit Control Systems and Corporate Governance policies.

I confirm that actions of Bank Management and Board has complied with laws and regulations. Audited results for the quarter have been reviewed by me in the Audit committee / Board Meeting and I confirm that the financial results are a correct representation of performance.

With a strong Board and Management team, I am confident that Xacbank will continue to achieve budgets and key metrics and stand out as a Leader in Corporate Governance.



Niraj Vedwa

Independent Director

2021 оны 7 дугаар сарын 12-ны өдөр

Монголбанкинд хүргүүлэх хараат бус гишүүн Нираж Вэдва-гийн ажлын улирлын тайлан (2021 оны 4 дүгээр сараас 6 дугаар сар хүртэл)

ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж буй Нираж Вэдва миний бие Монгол улсын Банкны тухай хууль, Банкны Дүрэмд заасан үүрэг хариуцлагыг гүйцэтгэж хэрэгжүүлсэн.

Би ТУЗ-ийн Аудитын хорооны болон Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр ажилладаг, 2021 оны 6 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд хуралдсан хороодын болон ТУЗ-ийн ээлжит хурлуудад оролцсон. Мөн сар бүр хийж буй ажлын явцын танилцуулгуудад оролцсон. 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцсон. Ковидтэй холбоотой хөдөлгөөний хязгаарлалтын улмаас ТУЗ-ийн бүх хурлыг видео холбооны хэрэгслээр дамжуулан явуулсан.

ТУЗ-ийн бүх хурлыг үр дүнтэй явуулж, хурлын хэлэлцэх асуудал, танилцах материалуудыг хурлаас өмнө гишүүдэд тараасан. Бүх шийдвэрийг санал хураалтын дүнд үндэслэн гаргасан. Хурлын гаргасан шийдвэрүүдтэй санал нэгтэй байсан бөгөөд зөрүүтэй байр суурьтай байсан асуудал гараагүй болно. Хурлаар хэлэлцэх асуудлуудын дотор сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаагүй.

ХасБанк зохистой засаглалын зарчмуудыг баримтладаг, Монгол улсын сайн удирдлагатай банкуудын нэг гэсэн нэр хүндээ хадгалсаар ирсэн. Хараат бус гишүүний хувьд зохистой засаглалыг зарчмуудыг дэмжиж ажилласан. Хороодын болон ТУЗ-ийн хурлуудаар хэлэлцсэн Банкны стратеги/Мэдээллийн технологийн стратеги/Цахим банк/Эрсдэлийн удирдлагын бодлого/Аудитын хороо/Жилийн төсөв/Бизнес төлөвлөгөө зэргийг хэлэлцэх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиглэлээр ажиллав. Үүнээс гадна дотоод аудитын хяналтын тогтолцоо, зохистой засаглалын бодлогуудыг хянах чиглэлээр ажиллав.

Банкны ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын гаргасан шийдвэрүүд хууль тогтоомжид нийцэж байгааг баталгаажуулж байна. Аудитлагдсан улирлын дүнг Аудитын хороо болон ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж хянасан бөгөөд санхүүгийн тайлангууд Банкны үр дүнг үнэн зөв харуулж байгааг мөн баталгаажуулж байна.

ТУЗ болон удирдлагын багийн хүчин чармайлтын үр дүнд ХасБанк цаашид улам амжилттай ажиллаж, төсөв болон зорилтот үзүүлэлтүүдийг хэрэгжүүлж, зохистой засаглалаар манлайлан ажиллана гэдэгт итгэлтэй байна.

/гарын үсэг/

Хараат бус гишүүн Нираж Вэдва